



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 6 сарын 01 өдөр

Дугаар 199

Улаанбаатар хот

Сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт
хийх төрийн бус байгууллагуудыг бүртгэх тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.13 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх журам”-ын 2.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх төрийн бус байгууллагуудыг хавсралтын дагуу бүртгэсүгэй.

2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх төрийн бус байгууллагуудад холбогдох хууль, журамд заасны дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг сонгуулийн хороодод зөвлөсүгэй.

3. Сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийхээр бүртгэгдсэн төрийн бус байгууллагуудад үйл ажиллагаандаа сонгуулийн тухай хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 188 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх журам”-ыг чанд мөрдөн ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА


Ч. Содиномцэрэн

Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц.Болдсайхан

Ц.БОЛДСАЙХАН



000572

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 6 дугаар сарын 01-ны өдрийн
199 дугаар тогтоолын хавсралт



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД АЖИГЛАЛТ, ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ ХИЙХ
ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУД**

1. “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгууллагуудын Шүхэр нэгдсэн бодлогын ерөнхий зөвлөл” НҮТББ
2. Бодлогод залуусын хяналт НҮТББ
3. Өөрчлөлтийн төлөө залуу эмэгтэйчүүд НҮТББ
4. МИДАС НҮТББ

--oOo--